



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

2020 оны 05 дугаар сарын 29
№21 /1123/

**Монгол Улсын
хууль**

**Хөгжлийн бодлого, төлөвлөлт,
түүний удирдлагын тухай
/шинэчилсэн найруулга/**

**Монгол Улсын
хууль**

**Төрийн тусгай хамгаалалтын
тухай хуульд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай**

**Монгол Улсын
хууль**

**Эрүүл мэндийн тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

222.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /шинэчилсэн найруулга/	975
223.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1003
224.	Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1005
225.	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1006
226.	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1007
227.	Улс төрийн намын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1008
228.	Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1008
229.	Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай	1012
230.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1013
231.	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1013
232.	Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт оруулах тухай	1014
233.	Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1014
234.	Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1015



235.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1015
236.	Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1016
237.	Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт оруулах тухай	1016
238.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	1017
239.	Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай	1017
240.	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1018
241.	Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	1018
242.	Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1019
243.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1022
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ		
244.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай	Дугаар 45 1022
245.	Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 56 1023

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой, залгамж чанарыг хангах, үндэсний хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчмыг тодорхойлох, хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээлэх, нэгдсэн, оновчтой тогтолцоог бүрдүүлэх, бодлого, төлөвлөлтийн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлох, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчдын түншлэлийг зохистойгоор хангах, бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөл, хэлбэрийг журамлахтай холбогдсон харилцааг зохицуулж, хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэхэд оршино.

2 дугаар зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль тогтоомж

2.1.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль², Монгол Улсын Засгийн газрын тухай хууль³, Төсвийн тухай хууль⁴, Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль⁵, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

² Үндэсний аюулгүй байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

³ Монгол Улсын Засгийн газрын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1993 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Төсвийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

⁵ Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2003 оны 23 дугаарт нийтлэгдсэн.



тухай хууль⁶, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь Монгол Улсын хөгжлийн бодлогыг боловсруулах, батлах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хөгжлийн бодлого” гэж улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд, урт, дунд, богино хугацаанд хөгжлийн тодорхой асуудлаар ахиц дэвшилд хүрэхээр дэвшүүлсэн хэмжигдэхүйц зорилго, зорилт, тэдгээрийн суурь түвшин, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээр баталгаажсан төсөв, хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг тусгасан эрх бүхий этгээдээс баталсан баримт бичгийг;

4.1.2.“хөгжлийн төлөвлөлт” гэж хөгжлийн бодлогын хэмжигдэхүйц зорилго, зорилтуудыг үе шаттайгаар тодорхой хугацаанд хэрэгжүүлэхээр тодорхойлсон төлөвлөгөөг боловсруулах үйл ажиллагааг;

4.1.3.“хөгжлийн төлөвлөлтийн үе шат” гэж хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, нөөцийг тогтоох, үнэлэх, хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, төлөвлөлтийг урт, дунд, богино хугацаанд улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд төлөвлөх, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах үйл ажиллагааг;

4.1.4.“Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” гэж Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэх, дэлхий нийтийн хөгжлийн түгээмэл хандлагыг өөрийн орны онцлогт тохируулан тусгасан, байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах, хүний хөгжлийг хангах, эдийн засаг, нийгэм, засаглалын хөгжлийг ахисан түвшинд хүргэхэд чиглэсэн урт хугацааны зорилго, зорилт, хүрэх үр дүн, үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтийг тусгасан баримт бичгийг;

4.1.5.“Хөгжлийн зорилтот хөтөлбөр” гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан тодорхой зорилт, арга хэмжээг

⁶ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2007 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр салбар, салбар хоорондын болон бүс, орон нутгийн онцлогт нийцсэн, нөөцөд суурилсан, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг тусгасан дунд хугацааны бодлогын баримт бичгийг;

4.1.6. “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт нийцүүлсэн улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн уялдааг хангасан зорилго, зорилт, хүрэх үр дүн, санхүүгийн эх үүсвэрийг нарийвчлан төлөвлөсөн үйл ажиллагаа, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт бүхий дунд хугацааны нэгдсэн төлөвлөлтийн баримт бичгийг;

4.1.7. “Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт суурилсан орон нутгийн онцлогийг тусгасан дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийг;

4.1.8. “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр” гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан зорилго, зорилтод нийцсэн, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөлтийн баримт бичгийг;

4.1.9. “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр” гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөлтийн баримт бичгийг;

4.1.10. “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр” гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн хавсралт баримт бичгийг;

4.1.11. “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө” гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичгийг;

4.1.12. “Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө” гэж Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан, тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичгийг;

4.1.13. “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг



боловсруулахдаа энэ хуульд заасан зарчмыг баримталсан байдал, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчдын чиг үүргээ хэрэгжүүлсэн болон хамтран ажилласан байдал, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүнд хийсэн цогц үнэлгээг;

4.1.14.“бодлогын зорилго” гэж улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн уялдааг хангасан, хүрч болохуйц эерэг өөрчлөлтийг;

4.1.15.“бодлогын зорилт” гэж бодлогын зорилгод нийцсэн, улс, салбар, салбар хооронд болон бүс орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн уялдааг хангасан үйл ажиллагааны бүрдлийг;

4.1.16.“бодлогын үр нөлөө” гэж бодлогыг хэрэгжүүлснээр хүний хөгжил, нийгэм, байгаль орчин, эдийн засаг, засаглалын хүрээнд бий болох эерэг өөрчлөлтийг;

4.1.17.“бодлогын хувилбар” гэж нөхцөл байдлын дүн шинжилгээ болон нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд үндэслэн асуудлыг шийдвэрлэхээр санал болгосон бодлогын хоёроос дээш сонголтыг;

4.1.18.“суурь түвшин” гэж төслийг боловсруулах үеийн шалгуур үзүүлэлтийн тоон болон чанарын үзүүлэлтийг;

4.1.19.“үйл ажиллагаа” гэж бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн оновчтой, хэмжигдэхүйц, тодорхой хугацаанд хүрч болохуйц арга хэмжээг;

4.1.20.“шалгуур үзүүлэлт” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн үе шат бүрд бий болох өөрчлөлтийг хэмжихээр төсөлд заасан тоон болон чанарын үзүүлэлтийг;

4.1.21.“зорилтот түвшин” гэж бодлогыг хэрэгжүүлэх явцад болон хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж байгаа өөрчлөлтийг төсөлд тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн тоон болон чанарын үзүүлэлтийг;

4.1.22.“бодлогын уялдааны үнэлгээ” гэж зорилго, зорилт, үйл ажиллагаа бүхий бодлогын баримт бичиг нь бусад урт, дунд, богино хугацааны, салбар болон салбар хоорондын түвшний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдах байдлын болон тэдгээрийн давхцал, хийдэл, зөрчлийн шинжилгээ, үнэлгээ, зөвлөмжийг;

4.1.23.“ерөнхий мэдээлэл” гэж бодлогыг оновчтой тодорхойлох зорилгоор төслийг боловсруулах үеийн хүн, нийгэм, байгаль



орчин, эдийн засгийн хөгжлийн түвшин, засаглалын нөхцөл байдлыг тодорхойлсныг;

4.1.24.“нөхцөл байдлын дүн шинжилгээ” гэж асуудлын шалтгаан, үр нөлөөг тоон болон чанарын мэдээлэлд үндэслэн хамрах хүрээний хамт тодорхойлсон бодлогын хувилбар боловсруулахад ашиглах судалгааг;

4.1.25.“нөлөөллийн урьдчилсан үнэлгээ” гэж бодлогыг хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны унаган төрх, тэнцвэрт байдал, түүнчлэн эрх зүйн орчин болон засаглалын тогтолцоонд үзүүлэх нөлөөллийн талаарх судалгааг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ЗАРЧИМ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ТӨРӨЛ

5 дугаар зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчим

5.1.Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд дараах зарчмыг баримтална:

- 5.1.1.үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх;
- 5.1.2.дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн байх;
- 5.1.3.нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;
- 5.1.4.тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх;
- 5.1.5.тэнцвэртэй байх;
- 5.1.6.нөөц, эх үүсвэрт үндэслэсэн байх;
- 5.1.7.ил тод, нээлттэй байх;
- 5.1.8.судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
- 5.1.9.зорилго, зорилт хэмжигдэхүйц байх;
- 5.1.10.шалгуур үзүүлэлт нь зорилготой нийцэж байх;
- 5.1.11.төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байх;
- 5.1.12.төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах;
- 5.1.13.бүх талын оролцоог хангасан байх;
- 5.1.14.төр-хувийн хэвшлийн түншлэлийг зохистойгоор хангах;
- 5.1.15.оролцогчдын хариуцлагын зарчим.

5.2.Энэ хуулийн 5.1-д заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зарчмыг доор дурдсан агуулгаар ойлгоно:

5.2.1.“үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх зарчим” гэж Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт



бичгүүд, тэдгээрийг хэрэгжүүлж байгаа Засгийн газрын үйл ажиллагаа нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлэхэд чиглэсэн байхыг;

5.2.2.“дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцсэн байх зарчим” гэж олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийн дагуу дэлхий нийтийн хөгжлийн зорилго, чиг хандлагыг үндэсний онцлогт нийцүүлэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт уялдуулан тусгахыг;

5.2.3.“нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, мэдээлэл, аргачлал нь нэгдмэл, уялдаатай байж, бодлогыг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны нэгдмэл байдлыг;

5.2.4.“тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, батлах, хэрэгжүүлэхдээ бодлогын тогтвортой байдлыг хадгалж, өмнө батлагдсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг хэрэгжилтийн үр дүн, үнэлгээнд үндэслэхийг;

5.2.5.“тэнцвэртэй байх зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн зорилго, зорилтууд, үйл ажиллагааг тодорхойлохдоо хүн, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалсан байхыг;

5.2.6.“нөөц, эх үүсвэрт үндэслэсэн байх зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, батлах, төлөвлөх, хэрэгжүүлэхдээ байгалийн баялаг, түүхий эд, хөрөнгө санхүү, техник технологи, шинжлэх ухаан, инновац, ур чадвартай ажиллах хүчин болон шаардлагатай бусад нөөцийг урьдчилан тооцоолсон төсөв, төсөөллийн дагуу тодорхойлсон хязгаарлалтын хүрээнд тусгахыг;

5.2.7.“ил тод, нээлттэй байх зарчим” гэж хуулиар хамгаалагдсан төрийн болон албаны нууцын зэрэглэлтэй мэдээлэл агуулснаас бусад тохиолдолд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг олон нийтэд ил тод мэдээлэх, албан ёсоор хэвлэн нийтлэхийг;

5.2.8.“судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн зорилго, зорилт, хүрэх үр дүнг тодорхойлохдоо нөөцийн хязгаарлалт болон эрсдэлийг харгалзан үзэж, тогтоосон хугацаанд биелүүлэх боломжтой, бодит, хэмжигдэхүйц зорилго, зорилт дэвшүүлэхийг;

5.2.9.“зорилго, зорилт хэмжигдэхүйц байх зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн зорилтын гүйцэтгэлийг бодлого, төлөвлөлтийн үйл явцад тодорхой тоон болон чанарын үзүүлэлт бүхий шалгуур үзүүлэлтийг ашиглан үнэлж, хэмжих боломжтой байхыг;

5.2.10.“шалгуур үзүүлэлт нь зорилготой нийцэж байх зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн гүйцэтгэлийг тоон болон чанарын үзүүлэлтээр хянах боломжтой байхыг;

5.2.11.“төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байх зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг хэрэгжүүлснээр бий болох үр дүнг тодорхойлж, түүнд чиглэсэн зорилго, зорилт, үйл ажиллагааг тодорхой зохион байгуулалт, дэс дарааллын дагуу төлөвлөхийг;

5.2.12.“төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах зарчим” гэж “дээрээс доош” төлөвлөх буюу нэгдсэн зорилго, зорилтыг дэвшүүлж салбар болон бүс нутгуудад хэрэгжүүлэх, “доороос дээш” төлөвлөх буюу төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүдийн саналыг нэгтгэн, нэгдмэл зорилго, зорилтыг тодорхойлж төлөвлөхийг;

5.2.13.“бүх талын оролцоог хангасан байх зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, иргэд, сонирхлын бүлгийн оролцоог ханган боловсруулсан байхыг;

5.2.14.“төр-хувийн хэвшлийн түншлэлийг зохистойгоор хангах зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд хувийн хэвшлийн хуулийн этгээдийг зохистойгоор оролцуулахыг;

5.2.15.“оролцогчдын хариуцлагын зарчим” гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчид нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн харилцаан дахь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийг тус тус ойлгоно.

5.3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч, Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулна.

5.4.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч, Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн



Хурлын сонгуульд оролцох улс төрийн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь энэ хуулийн 5.3-т заасан баримт бичигт нийцсэн эсэхийг төрийн аудитын байгууллага хянаж, Сонгуулийн ерөнхий хороонд дүгнэлтээ хүргүүлнэ.

5.5.Энэ хуульд заасан зарчимд нийцүүлэн Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг нь тогтвортой хэрэгжих бөгөөд шинээр байгуулагдсан Улсын Их Хурал, Засгийн газар тухайн баримт бичгийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй.

6 дугаар зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөл

6.1.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг нь дэвшүүлсэн зорилго, зорилтоо хангахад чиглэгдсэн, харилцан уялдаа бүхий дараах төрөлтэй байна:

- 6.1.1.урт хугацааны;
- 6.1.2.дунд хугацааны;
- 6.1.3.богино хугацааны.

6.2.30 хүртэл жилийн хугацаанд хэрэгжүүлэх “Алсын хараа” нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг байна.

6.3.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг нь дунд болон богино хугацааны бодлого, төлөвлөлтийн үндэс байна.

6.4.Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн болон хотын ерөнхий төлөвлөгөөг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт үндэслэнэ.

6.5.Дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа бүхий, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх дараах Хөгжлийн зорилтот хөтөлбөр байна:

- 6.5.1.хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- 6.5.2.нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- 6.5.3.эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр;
- 6.5.4.байгаль орчны зорилтот хөтөлбөр;
- 6.5.5.засаглалын зорилтот хөтөлбөр;

6.5.6.бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр;
6.5.7.үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр.

6.6.Энэ хуулийн 6.5.3, 6.5.5-д заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төрөлд хамаарах баримт бичгийн төслийг Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагаас боловсруулах бол үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн боловсруулж, холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.

6.7.Дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл байна.

6.7.1.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь дараах шаардлагыг хангасан байна:

6.7.1.а.урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд нөөцөд суурилан боловсруулсан, санхүүгийн эх үүсвэрийг нарийвчлан тусгасан үйл ажиллагаа, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх тухайн таван жилд хэрэгжүүлэх эрэмбэ дараалал бүхий арга хэмжээ байх;

6.7.1.б.хүн, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулахад чиглэсэн салбар болон салбар хоорондын уялдааг хангасан байх;

6.7.1.в.зорилт, арга хэмжээг салбар, бүс нутаг, байршил, санхүүжилтийн эх үүсвэр, жил бүрийн задаргаагаар боловсруулсан байх;

6.7.1.г.улсын хөрөнгө оруулалтын болон шаардлагатай бусад хөтөлбөрийг хавсаргах.

6.7.2.Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь дараах шаардлагыг хангасан байна:

6.7.2.а.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцсэн, түүнд тусгасан арга хэмжээг аймаг, нийслэл, хотын түвшинд хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;

6.7.2.б.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилт, арга хэмжээг орон нутгийн онцлогийг харгалзан нарийвчлан төлөвлөсөн, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх тухайн таван жилд хэрэгжүүлэх эрэмбэ дараалал бүхий арга хэмжээ байх;



6.7.2.в.аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөтөлбөрийг хавсаргах.

6.8.Богино хугацааны буюу дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр байна:

6.8.1.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байна:

6.8.1.а.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилт, арга хэмжээг бүрэн тусгасан байх;

6.8.1.б.Хөгжлийн зорилтот хөтөлбөрт заасан төсөл, арга хэмжээтэй уялдсан байх;

6.8.1.в.хүн, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулахад чиглэсэн салбар болон салбар хоорондын уялдааг хангасан байх;

6.8.1.г.зорилт, арга хэмжээг салбар, бүс нутаг, байршил, санхүүжилтийн эх үүсвэр, жил бүрийн задаргаагаар боловсруулсан байх.

6.8.2.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байна:

6.8.2.а.Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх арга замыг сонгон боловсруулсан байх;

6.8.2.б.Хөгжлийн зорилтот хөтөлбөрт заасан төсөл, арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;

6.8.2.в.тухайн орон нутгийн хүн, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулахад чиглэсэн улсын, бүсийн болон орон нутгийн хөгжлийн зорилтуудтай уялдсан байх;

6.8.2.г.зорилт, арга хэмжээг санхүүжилтийн эх үүсвэр, жил бүрийн задаргаагаар боловсруулсан байх;

6.8.2.д.бүс нутгийн хүрээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоо бэхжүүлж, харилцан уялдаатай хөгжих боломжийг хангасан байх.

6.9.Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөв хамаарна.

6.10.Нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан байна:

6.10.1.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх;

6.10.2.санхүүжилтийн баталгаат эх үүсвэртэй, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан тухайн жилд хэрэгжих төсөл, арга хэмжээний задаргаа байх;

6.10.3.улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;

6.10.4.орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦОО, ОРОЛЦОГЧДЫН ЭРХ, ҮҮРЭГ

7 дугаар зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо

7.1.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо нь улсын түвшинд үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, салбарын түвшинд төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагууд, орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгжээс бүрдэнэ.

7.2.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг улсын түвшинд Монгол Улсын Шадар сайдын тэргүүлсэн үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, салбарын түвшинд тухайн салбарын сайд, тухайн салбарын төрийн захиргааны байгууллагын дарга, орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар удирдана.

7.3.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Үндэсний хөгжлийн хүрээлэн нь үндэсний



хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд ажиллана.

8 дугаар зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогч

8.1.Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд доор дурдсан оролцогч оролцоно:

8.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгч;

8.1.2.Монгол Улсын Их Хурал;

8.1.3.Монгол Улсын Засгийн газар;

8.1.4.үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

8.1.5.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

8.1.6.төрийн захиргааны төв байгууллагууд;

8.1.7.Үндэсний статистикийн хороо;

8.1.8.төрийн аудитын байгууллага;

8.1.9.төв банк;

8.1.10.аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга;

8.1.11.аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн

Хурал;

8.1.12.Үндэсний хөгжлийн хүрээлэн, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага;

8.1.13.улс төрийн нам;

8.1.14.хувийн хэвшил.

8.2.Энэ хуулийн 8.1-д зааснаас бусад төрийн захиргааны байгууллага, шинжлэх ухааны төв байгууллага, төрийн өмчит хувьцаат компани, сан, Хөгжлийн банк, төрийн гүйцэтгэх байгууллагын чиг үүргийг эрхлэн гүйцэтгэгчид, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагууд болон хувийн хэвшлийн хуулийн этгээд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд оролцоно.

9 дүгээр зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчийн эрх, үүрэг

9.1.Монгол Улсын Ерөнхийлөгч хөгжлийн бодлого, төлөвлөлтийн харилцаанд Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэх замаар оролцоно.

9.2.Улсын Их Хурлын бүрэн эрх:

9.2.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг ялдуулан батлах;

9.2.2.энэ хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.8, 4.1.10, 4.1.11-д заасан баримт бичгийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасныг тус тус баримтлан батлах;

9.2.3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон энэ хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.6-д заасан баримт бичигт нийцүүлэн батлах;

9.2.4.энэ хуулийн 6.6-д заасны дагуу хүргүүлсэн Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг хэлэлцэн батлах;

9.2.5.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, дүгнэлт гаргуулах, түүнчлэн холбогдох судалгаа, шинжилгээ, явцын болон эцсийн үнэлгээг үндэслэн хөгжлийн бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах талаар Засгийн газарт чиглэл өгөх;

9.2.6.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, жил бүрийн төсвийг Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн батлах;

9.2.7.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг хэлэлцэж, шаардлагатай бол Засгийн газарт чиглэл өгөх, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг Ерөнхий сайдад хүргүүлэх;

9.2.8.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн гүйцэтгэлийн үр дүнгээс хамаарч Засгийн газрын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах, шаардлагатай бол Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлд заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулах саналыг гаргах;

9.2.9.Улсын Их Хурал Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасан хөгжлийн бодлого, төлөвлөлт



тогтвортой байх зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор энэ хуульд заасан зарчмыг баримтлаагүй, шаардлагыг хангаагүй хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг Улсын Их Хурал хэлэлцэн батлахгүй байх.

9.3.Засгийн газрын бүрэн эрх:

9.3.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу Улсын Их Хурлаас баталсан энэ хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.8, 4.1.10, 4.1.11-д заасан баримт бичгийг хэрэгжүүлэх;

9.3.2.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулж хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

9.3.3.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг улсын түвшинд удирдан зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах үйл ажиллагааг улсын хэмжээнд хариуцан зохион байгуулах;

9.3.4.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг энэ хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах;

9.3.5.нийгэм, байгаль орчин, эдийн засаг, засаглалын тогтвортой хөгжлийн тэргүүлэх чиглэл, хөгжлийн нэгдсэн зорилт, үйл ажиллагааны эрэмбэ дарааллыг тодорхойлох;

9.3.6.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдаа холбоо, нийцлийг хангаж, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах;

9.3.7.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, хянан үзэх, төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, гүйцэтгэлийг дүгнэх журмыг батлах;

9.3.8.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журам, тайлангийн үлгэрчилсэн загвар батлах;

9.3.9.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн аливаа асуудлаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тодорхой үүрэг, чиглэл өгөх;

9.3.10.хуульд заасан бусад.

9.4.Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг:

9.4.1.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг улс, салбар, салбар хоорондын болон бүс болон орон нутгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах;

9.4.2.Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу энэ хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.8, 4.1.10, 4.1.11-д заасан баримт бичгийн төслийг энэ хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулж, Засгийн газарт танилцуулах;

9.4.3.макро эдийн засгийн бодлого болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг салбар хооронд шууд удирдан зохион байгуулах бөгөөд улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгөх;

9.4.4.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлох;

9.4.5.хөгжлийн бодлого, төлөвлөлтөд шаардлагатай мэдээлэл, судалгаа, тодорхой салбарын хөгжлийн асуудлаар санал, дүгнэлт, төлөвлөгөөний төслийг төрийн бүх шатны байгууллага болон холбогдох бусад байгууллагаас гаргуулан авах;

9.4.6.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд шаардагдах журмын төслийг холбогдох яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагатай хамтран боловсруулж, Засгийн газраар хэлэлцүүлэх;

9.4.7.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад төрийн бүх шатны болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хувийн хэвшлийн төлөөллийг хангаж, их, дээд сургууль, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, иргэний оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлэх;

9.4.8.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах;



9.4.9.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн бүртгэл хөтлөх журам, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сангийн журам батлах;

9.4.10.мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, ангилах, бүртгэл хөтлөх, мэдээллийн санг бүрдүүлэх, шинэчлэх, хянан үзэх, мэдээллийг эргэлтэд оруулах болон мэдээллийн сантай холбоотой бусад ажлыг эрхлэн гүйцэтгэх;

9.4.11.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар баримтлах чиглэлийг тодорхойлох, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх;

9.4.12.Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн судалгаа, боловсруулалтын ажилд шаардагдах хөрөнгө, тоног төхөөрөмж, санхүү, боловсон хүчний нөөцөөр хангах;

9.4.13.хуульд заасан бусад.

9.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх чиг үүрэг:

9.5.1.улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлтийг хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах;

9.5.2.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрээр хангах;

9.5.3.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний төсөв, хөрөнгийн эх үүсвэрийг хянаж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрээр хангах.

9.6.Төрийн захиргааны төв байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх чиг үүрэг:

9.6.1.энэ хуулийн 4.1.4, 4.1.5, 4.1.6, 4.1.8, 4.1.10, 4.1.11-д заасан баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд оролцох;

9.6.2.энэ хуулийн 9.6.1-д заасан баримт бичигт тусгах саналаа үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн



захиргааны төв байгууллагад хүргүүлж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, батлах, төлөвлөхөд шаардлагатай өөрийн эрхлэх асуудлын хүрээний тоо баримт, судалгаа, мэдээллийг хууль тогтоомжид заасан хугацаанд шуурхай гарган хүргүүлэх;

9.6.3.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын санал, тооцооллыг нэгтгэн боловсруулж, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг батлагдсаны дараа хэрэгжилтийг өөрийн салбарын хэмжээнд зохион байгуулах;

9.6.4.өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хууль тогтоомжид заасан хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан, дүгнэлтийг Засгийн газар болон үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

9.6.5.хуульд заасан бусад.

9.7.Үндэсний статистикийн хорооны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх чиг үүрэг:

9.7.1.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, бодлого төлөвлөх, гүйцэтгэлийг үнэлэх, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд шаардагдах албан ёсны статистикийн мэдээллийг тухай бүрд нь боловсруулж үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн болон бусад төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

9.7.2.үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад төрийн захиргааны байгууллагад хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад шаардлагатай шалгуур үзүүлэлт, түүний эх үүсвэр, тооцох аргачлалыг тодорхойлох, бий болгоход шаардлагатай арга зүй, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах;

9.8.Төрийн аудитын байгууллагын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх чиг үүрэг:

9.8.1.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт Төрийн аудитын тухай хуульд⁷ заасан аудит хийж Улсын Их Хуралд танилцуулах;

⁷ Төрийн аудитын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2020 оны 20 дугаарт нийтлэгдсэн.



9.8.2.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт хийсэн аудитын зөвлөмж, дүгнэлтийг тайлангийн хамт үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

9.9.Төв банкны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх чиг үүрэг:

9.9.1.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах;

9.9.2.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд холбогдох санал өгөх;

9.9.3.хуульд заасан бусад.

9.10.Аймаг, нийслэлийн Засаг даргын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх чиг үүрэг:

9.10.1.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулж, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

9.10.2.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг боловсруулахад холбогдох саналаа үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

9.10.3.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хууль тогтоомжид заасан хугацаанд Засгийн газар болон үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тус тус хүргүүлэх;

9.10.4.Засаг дарга сум, дүүргийн түвшинд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдааг хангах, үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

9.10.5.Засаг дарга энэ хуулийн 9.10.1, 9.10.2, 9.10.3, 9.10.4-д заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ энэ хуулийг дагаж мөрдөх.

9.11.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх чиг үүрэг:

9.11.1.тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөртэй уялдсан эсэх талаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн саналыг харгалзан тухайн бодлогын баримт бичгийг хэлэлцэн, батлах, эсхүл буцаах.

9.12.Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх чиг үүрэг:

9.12.1.улсын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн арга зүйг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай судалгаа, шинжилгээ хийх;

9.12.2.үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан болон нэмж тусгах төсөл, хөтөлбөрийн бодлогын судалгаа, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах;

9.12.3.эдийн засгийн хөгжлийн суурь дэвсгэр болох хүн ам, хөдөлмөрийн нөөц, эдийн засгийн эргэлтэд оруулах малын гаралтай түүхий эд, ус, газрын баялгийн нөөцийн судалгааг байршлаар нарийвчлан хийж, хүн ам, хөдөлмөрийн нөөцийн төсөөлөл, нөөцийг ашиглах оновчтой арга замыг тодорхойлох;

9.12.4.дэлхийн улс орнуудын туршлага, арга хөгжлийн чиг хандлагыг судалж өөрийн орны онцлогт тохирсон хөгжлийн загвар боловсруулах, нэвтрүүлэх;

9.12.5.салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудтай хамтран хөгжлийн бодлого, төлөвлөлтөд шаардлагатай норм, норматив, стандартыг боловсруулж үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;



9.12.6.олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн хөгжлийн судалгааны байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоох, үндэсний хэмжээнд бодлого, төлөвлөлтийн хүний нөөцийг сургах, чадавхжуулах, дэвшилтэт техник, технологи, багаж хэрэгсэл ашиглах, судалгаа шинжилгээний хамтарсан арга хэмжээ зохион байгуулах;

9.12.7.үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, шинэчлэх үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа үзүүлэх;

9.12.8.үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу ажиллах, үйл ажиллагааныхаа биелэлтийг тайлагнах.

9.13.Улсын Их Хурал Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэн батлах үед улс төрийн нам төсөлд холбогдох саналаа төслийн анхны хэлэлцүүлэг эхлэхээс өмнө Улсын Их Хуралд албан ёсоор хүргүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ ҮЕ ШАТ, ЦАГЛАВАР, НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

10 дугаар зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах үе шат

10.1.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг дараах дарааллын дагуу боловсруулна:

10.1.1.улсын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг тодорхойлсон нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх;

10.1.2.нөхцөл байдлын дүн шинжилгээгээр тогтоосон асуудлыг шийдвэрлэх хөгжлийн загвар, төсөөлөл, үр нөлөө, гарах үр дүн, нөөцийн судалгаа, санхүүгийн хэмжээ, эх үүсвэрийн тооцоолол хийж, бодлогын хувилбарыг боловсруулах;

10.1.3.бодлогын хувилбаруудад хүний хөгжлийн, эдийн засаг, нийгмийн хөгжлийн урьдчилсан үнэлгээ болон байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлоготой уялдах байдлын үнэлгээ, үр ашгийн урьдчилсан тооцоо хийх;

10.1.4.бодлогын хувилбарыг энэ хуулийн 10.1.3-т заасныг үндэслэн, энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан сонгох;

10.1.5.бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг эрэмбэ дараалал, үе шатаар тооцож тодорхойлох;

10.1.6.бодлогын баримт бичгийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшинд үндэслэн үйл ажиллагаа, бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлох.

11 дүгээр зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад тавих шаардлага

11.1.Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулахдаа энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг баримтална.

11.2.Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөлд зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, хэрэгжүүлэх арга зам, үе шат, хүрэх үр дүн, бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгэм, байгаль орчинд бий болох үр нөлөө, эрсдэл, санхүүгийн эх үүсвэр, хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө, хариуцах байгууллагыг тусгана.

11.3.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулахдаа олон талын оролцоог хангасан байх ба эцэслэгдсэн төслийг олон нийтээр хэлэлцүүлнэ.

12 дугаар зүйл.Урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн цаглавар

12.1.Засгийн газар Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцыг таван жил тутам, гүйцэтгэлийн тайланг дуусгавар болох хугацаанаас хоёр жилийн өмнө Улсын Их Хуралд танилцуулна.

12.2.Улсын Их Хурал хэрэгжилтийн явцын үнэлгээнд үндэслэн Засгийн газарт Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх чиглэл өгч болно.

12.3.Засгийн газар Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг нэг жилийн хугацаанд боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.



12.4.Улсын Их Хурал өмнөх бодлогын баримт бичиг дуусгавар болохоос зургаан сарын өмнө урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг батална.

13 дугаар зүйл.Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн цаглавар

13.1.Засгийн газар Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын тайланг 5 жил тутам, гүйцэтгэлийн тайланг тухайн баримт бичгийг дуусгавар болохоос 2 жилийн өмнө Улсын Их Хуралд танилцуулна.

13.2.Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг тооцно.

13.3.Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлан хэрэгжүүлнэ.

14 дүгээр зүйл.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн цаглавар

14.1.Засгийн газар Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хугацаа дуусгавар болохоос нэг жилийн өмнө хэрэгжилтийн үнэлгээг Улсын Их Хуралд танилцуулна.

14.2.Улсын Их Хурал тус үнэлгээнд үндэслэн Засгийн газарт дараагийн таван жилийн үндсэн чиглэлийг боловсруулахтай холбогдсон чиглэл өгч болно.

14.3.Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Үндэсний хөгжлийн хүрээлэн, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, бусад төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн хуулийн этгээдийг оролцуулан Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, Засгийн газарт танилцуулна.

14.4.Засгийн газар Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг өмнөх үндсэн чиглэлийн баримт бичиг дуусгавар болохоос зургаан сарын өмнө Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

14.5.Улсын Их Хурал Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг өмнөх үндсэн чиглэлийн баримт бичиг дуусгавар болох хугацаанаас гурван сарын өмнө батална.

15 дугаар зүйл. Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн цаглавар

15.1. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд суурилсан Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн аймаг, нийслэл, хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан захиргааны байгууллагатай хамтран өмнөх төлөвлөгөөний баримт бичиг дуусгавар болохоос нэг жилийн өмнө боловсруулна.

15.2. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь аймаг, нийслэлийн Засаг даргын өргөн мэдүүлсэн Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан үйлчлэх хугацаанаас зургаан сарын өмнө батална.

16 дугаар зүйл. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн цаглавар

16.1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

16.2. Засгийн газар үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

16.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газар батална.

17 дугаар зүйл. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн цаглавар

17.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга үйл ажиллагааныхаа хөтөлбөрийн хэрэгжилтийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хууль тогтоомжид заасан хугацаанд танилцуулна.

17.2. Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч, Засаг даргыг томилогдсоны дараах нэг сарын дотор багтаан боловсруулна.



17.3.Сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгжийн саналыг авч, Засаг даргыг томилогдсоны дараах нэг сарын дотор багтаан боловсруулна.

17.4.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг Засаг даргыг томилогдсоны дараах 45 хоногт багтаан батална.

17.5.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тухайн шатны Засаг дарга батлан хэрэгжүүлнэ.

18 дугаар зүйл.Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний цаглавар

18.1.Төрийн захиргааны төв болон холбогдох төрийн захиргааны байгууллага нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг төсвийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгжийн саналыг нэгтгэн боловсруулж, жил бүрийн 3 дугаар сарын 01-ний дотор үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

18.2.Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь үндэсний хөгжлийн хүрээлэн, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургууль, бусад төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн хуулийн этгээдийг оролцуулан Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор боловсруулна.

18.3.Засгийн газар Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт болон дараа жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 5 дугаар сарын 25-нд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

18.4.Улсын Их Хурал Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг 7 дугаар сарын 01-ний дотор батална.

18.5.Хөгжлийн асуудал хариуцсан аймаг, нийслэлийн байгууллагууд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд суурилсан Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг 9 дүгээр сарын 01-ний дотор боловсруулна.

18.6.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор батална.

19 дүгээр зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах

19.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт дараах тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулж болно:

19.1.1.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын дүгнэлт, зөвлөмжөөр түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай нь нотлогдсон байх;

19.1.2.гадаад, дотоод орчны нөлөөлөл, хүчин зүйлээс шалтгаалан улсын эдийн засаг, нийгэм, төсөв, санхүүгийн нөхцөл байдал өөрчлөгдсөн байх;

19.1.3.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсон байх.

19.2.Дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлнэ.

19.3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуулийн үр дүн нь урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл болохгүй.

19.4.Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжид үндэслэн тухайн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах болон шаардлагатай арга хэмжээ авах үйл ажиллагааг холбогдох байгууллага, албан тушаалтан хариуцан зохион байгуулна.

20 дугаар зүйл.Санхүүжилтийн эх үүсвэр

20.1.Дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байна.



20.2.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг хэрэгжүүлэх санхүүжилт нь дараах эх үүсвэртэй байна:

- 20.2.1.улсын болон орон нутгийн төсөв;
- 20.2.2.гадаадын зээл, тусламж;
- 20.2.3.гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;
- 20.2.4.Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас;
- 20.2.5.концессын гэрээ;
- 20.2.6.бусад эх үүсвэр.

ТАВДУГААР БҮЛЭГ
ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

21 дүгээр зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт
бичгийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

21.1.Засгийн газар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргана.

21.2.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны зорилго нь баримт бичгийн төлөвлөлт, биелэлтэд чанарын үнэлгээ хийх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, шийдвэр нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, үр нөлөөг үнэлэхэд оршино.

21.3.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд дараах үе шатаар цогц хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ:

- 21.3.1.мэдээллийг цуглуулах, ангилах, нэгтгэх;
- 21.3.2.зорилтын биелэлтийн дүнг үнэлэх;
- 21.3.3.биелэлтийн үр нөлөөг үнэлэх;
- 21.3.4.гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллийг үнэлэх;
- 21.3.5.төлөвлөлт, хэрэгжилтийн харилцан хамаарлыг үнэлэх;
- 21.3.6.биелэлтийн түвшинг үнэлэх;
- 21.3.7.бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах тодорхой санал боловсруулах.

21.4.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт гаргах журмыг Засгийн газар батална.



21.5.Салбарын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтын биелэлтийг жил бүр тогтоосон хугацаанд Засгийн газарт ирүүлнэ.

21.6.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтуудын орон нутаг дахь хэрэгжилтийн явц, үр нөлөөний тайланг аймаг, нийслэлийн Засаг даргаас Засгийн газарт тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

21.7.Засгийн газар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт, түүний явцын талаар Улсын Их Хуралд тогтоосон хугацаанд танилцуулж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санд байршуулахаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦОО

22 дугаар зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан

22.1.Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулан зохицуулах зорилгоор мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, эрхлэн хөтөлнө.

22.2.Мэдээллийн нэгдсэн санд эрх бүхий байгууллагын баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, түүнтэй холбогдох тайлан, судалгаа, шинжилгээ, тооцоолол, дүгнэлт, зөвлөмжийг дэвшилтэт технологи ашиглан бүрдүүлнэ.

22.3.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээлэл нь холбогдох эрх зүйн акт, тайлан, дүгнэлт, судалгаа, шинжилгээ, баримтаар баталгаажсан байна.

22.4.Холбогдох байгууллага, албан тушаалтан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санд оруулах үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлэх үүрэгтэй.

22.5.Мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтлөх журмыг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв



байгууллага баталж, мэдээллийн сангийн ангилалт, бүрдүүлэлт, бүртгэл, хадгалалт, хамгаалалт, программчлал, хөгжлийн загвар боловсруулалт, шинэчлэлийг хариуцан зохион байгуулна.

23 дугаар зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг хэвлэн нийтлэх, сурталчлах

23.1.Батлагдсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулна.

23.2.Салбарын бодлогын залгамж чанарыг хадгалах зорилгоор төрийн захиргааны төв байгууллага өмнө хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, цаашид авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, хэвлэн нийтэлнэ.

23.3.Энэ хуулийн 23.2-т заасан хэвлэн нийтэлсэн мэдээллийн хувийг тухайн төрийн захиргааны төв байгууллага үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

24 дүгээр зүйл.Хориглох зүйл, хүлээлгэх хариуцлага

24.1.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтыг хангахаар боловсруулж, баталсан дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт сонгуулийн мөрийн хөтөлбөрөө нийцүүлэн боловсруулаагүй улс төрийн нам, эвсэл сонгуульд оролцохыг хориглоно.

24.2.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглээгүй Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг Улсын Их Хурал батлахыг хориглоно.

24.3.Засгийн газар үйл ажиллагааныхаа хөтөлбөрөө боловсруулахдаа энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчим болон энэ хуулийн 6.5.1-д заасныг баримталсан байна.

24.4.Энэ хуулийн 4.1.6, 4.1.10-т заасан төлөвлөлтийн баримт бичигт туссан салбарын үзүүлэлтээ жигд ханган биелүүлээгүй нь Засгийн газрын гишүүнийг болон энэ хуулийн 4.1.7, 4.1.12-т заасан төлөвлөлтийн баримт



бичигт туссан орон нутгийн үзүүлэлтээ жигд ханган биелүүлээгүй нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргыг огцруулах үндэслэл болно.

24.5.Энэ хуулийг зөрчсөн төрийн албан хаагч, албан тушаалтан, хуулийн этгээдийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол тэдгээрт Төрийн албаны тухай⁸, Зөрчлийн тухай хууль⁹ болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

25 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

25.1.Энэ хуулийг 2020 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Ерөнхий чиг үүргийн” гэсэн заалтад доор дурдсан агуулгатай 7 дахь дэд заалт, 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “1/ Монгол Улсын Шадар сайд,” гэсэн заалтын дараа доор дурдсан агуулгатай 2/ дахь заалт тус тус нэмсүгэй:

1/18 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 7 дахь дэд заалт:

“7/Хөгжлийн төлөвлөлт, эдийн засгийн яам;”

2/20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 2 дахь заалт:

“2/Монгол Улсын Шадар сайд:

⁸ Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

⁹ Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.



-хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох;
-үндэсний хөгжлийн, бодлого төлөвлөлт;
-бүс, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт;
-макро эдийн засгийн бодлогын төлөвлөлт;
-худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт;
-салбар хоорондын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн уялдаа, нийцтэй байдлыг хангах;

-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах;

-Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах;
-Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон түүнд хавсаргах улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах;

-Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөл боловсруулах;
-Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах;
-хөнгөн, жижиг, дунд болон аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт;

-төр-хувийн хэвшлийн түншлэлийн бодлого;
-өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцоог хөгжлийн бодлого, төлөвлөлтөд нэвтрүүлэх;

-чөлөөт бүсийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал;”

2 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 2 дугаар зүйлийн “Захиргааны ерөнхий хууль,” гэсний дараа “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/8 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг:

“1.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон улсын төсвийг боловсруулахад Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлсон төсвийн хүрээний мэдэгдлийг Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

2.Улсын төсвийн төслийг Улсын Их Хурлаас баталсан урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг

хэрэгжүүлэхэд чиглэсэн Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлнэ.

3.Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөө, улсын төсвийн биелэлтийг хангах ажлыг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаар дамжуулан зохион байгуулна.”

4 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “7, 8, 9, 10, 11, 12, 13” дахь дэд заалтын дугаарыг “8, 9, 10, 11, 12, 13, 14” гэж, 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15” дахь дэд заалтын дугаарыг “3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 1 дэх заалтын “чөлөөт бүсийн хөгжлийн асуудал,” гэснийг, мөн хэсгийн 2 дахь заалтын “орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого,” гэснийг, мөн хэсгийн 6 дахь заалтын “макро эдийн засгийн бодлогын төлөвлөлт, зохицуулалт;”, “улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийн асуудал;”, “хилийн боомтын хөгжлийн асуудал;” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:



1/6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Үндэсний хорооны дарга нь үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн шадар сайд, орлогч дарга нь Засгийн газрын гишүүн-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга байна.”

2/6 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Үндэсний хороо нь ажлын албатай байна. Ажлын албаны үүргийг үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгж хэрэгжүүлнэ.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА,
НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ
УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын а, е дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын а дэд заалт:

“а/Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.10, 9.11-д заасны дагуу Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд санал өгөх;”

2/18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын е дэд заалт:

“е/нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжил, хэтийн төлөвийг бүсчилсэн хөгжлийн зорилтот хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын таван жилийн үндсэн чиглэл, хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн болон хотын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх;”

2 дугаар зүйл.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын а/ дэд заалтын “нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн” гэснийг “Аймаг, нийслэл, хотын таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр баталсан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улс төрийн намын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “хөгжлийн үзэл баримтлал” гэснийг “урт хугацааны хөгжлийн бодлого,” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт:

“9/хуулиар төрийн тусгай хамгаалалтад байхаар тогтоосон Улсын Их Хурлын чуулган, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан, олон улсын дээд хэмжээний уулзалт, хэлэлцээ, хурал, зөвлөгөөн явагдах танхим, хамгаалуулагчийн ордон, өргөө, зориулалтын орон сууц, тээврийн хэрэгсэл болон түр байрлах орон байр, албан тасалгаанд техникийн үзлэг, шалгалт хийх.”

2/13 дугаар зүйлийн 3-5 дахь хэсэг:

“3.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэнэ.

4.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан тушаалд иргэнийг сонгон шалгаруулах, туршилтын хугацаагаар ажиллуулах журмыг Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын саналыг үндэслэн Засгийн газар батална.

5.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн ёс зүйн дүрмийг Засгийн газар батална.”

2 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/10 дугаар зүйл:

“10 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага

1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага /цаашид “Төрийн тусгай хамгаалалтын газар” гэх/ нь төрийн тусгай хамгаалалтын чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх Засгийн газрын тохируулагч агентлаг мөн.

2.Төрийн тусгай хамгаалалтын газар хамгаалалт, үйлчилгээ, захиргаа, сургалт, тусгай зориулалтын болон дүн шинжилгээний нэгжтэй байх бөгөөд зохион байгуулалтын бүтцийг төрийн тусгай хамгаалалтын иж бүрэн байх зарчимд нийцүүлэн Засгийн газар тогтооно.

3.Төрийн тусгай хамгаалалтын газар туг, бэлгэ тэмдэгтэй байна. Туг, бэлгэ тэмдгийн загвар, хэрэглэх журмыг Засгийн газар батална.

4.Төрийн тусгай хамгаалалтын газар тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

5.Төрийн тусгай хамгаалалтын газрын даргаар Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг шаардлагаас гадна төрийн тусгай албанд 16-аас доошгүй жил, үүнээс төрийн тусгай хамгаалалтын албанд 5-аас доошгүй жил ажилласан, удирдах болон мэргэжлийн ажлын дадлага туршлагатай Монгол Улсын иргэнийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүдтэй зөвшилцөн Ерөнхий сайдын санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө.

6.Төрийн тусгай хамгаалалтын газрын удирдах албан тушаалтанд цэргийн дээд цол олгож болно.

7.Төрийн тусгай хамгаалалтын газар улсын төсвөөс санхүүжнэ.



8.Төрийн тусгай хамгаалалтын газрын төсвийг Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооноос хянаж, санал болгосноор Улсын Их Хурал батална.”

2/12 дугаар зүйл:

“12 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын бүрэн эрх

1.Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/төрийн тусгай хамгаалалтын газрын хүний нөөцийг бэлтгэх, зэвсэг, техникээр хангах, бэхжүүлэх талаарх саналаа Засгийн газарт танилцуулж, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

2/төрийн тусгай хамгаалалтын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, биелэлтийг хангуулах;

3/энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 9-д заасан техникийн үзлэг, шалгалт хийх зөвшөөрөл олгох;

4/батлагдсан төсвийг тогтоосон журмын дагуу захиран зарцуулах, түүний гүйцэтгэлд хяналт тавих;

5/хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу албан хаагчийг томилох, чөлөөлөх, цэргийн цол олгох, бууруулах, хураах, сэргээх, шагнаж урамшуулах, ёс зүй, сахилгын хариуцлага хүлээлгэх;

6/төрийн тусгай хамгаалалтад оролцож байгаа бусад байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хамтарсан шийдвэр гаргаж хэрэгжүүлэх;

7/байгууллагыг төлөөлөн дотоод, гадаадын байгууллагатай харилцан ажиллах.”

3/16 дугаар зүйл:

“16 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа

1.Албан үүргээ биелүүлэх үед нь төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид учирсан хохирлыг төр хариуцна.



2.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн ажлыг захирах даргад нь мэдэгдэлгүйгээр шалгах, албан үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулах, хуулиар хүлээсэн үүрэгт нь үл хамаарах ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

3.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчаас ажил үүрэгтэй нь холбоотой асуудлаар гэрч, хохирогчийн хувиар мэдүүлэг авах тохиолдолд Төрийн тусгай хамгаалалтын газрын даргад мэдэгдэнэ.

4.Гүйцэтгэж байгаа ажил үүрэгтэй нь холбогдуулан төрийн тусгай хамгаалалтын алба хаагч болон түүний гэр бүлийн гишүүний амь биед аюул учирч болзошгүй бодитой нөхцөл байдал бий болсон тохиолдолд тэдгээрийг хамгаалалтад авч болно.

5.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн цалин хөлс Төрийн албаны тухай хуулийн 57.2.3-т заасан цалин, нэмэгдлээс бүрдэнэ.

6.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны болон мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам, нэмэгдлийн хэмжээг Засгийн газар тогтооно.

7.Төрийн тусгай хамгаалалтын албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн хэмжээ, сүлжээг Засгийн газар тогтооно.

8.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид жил бүр ажлын 15 өдрийн амралт олгох ба төрийн алба хаасан 5 жил тутамд ажлын 2 өдрийн нэмэгдэл амралт олгоно.

9.Өндөржүүлсэн бэлэн байдал, ажлын бус цагаар болон шөнийн ээлжид ажиллах үед хоол, унааны зардал, сургалт, дадлагын үед хүнсний болон эдийн хангалтыг төрийн тусгай хамгаалалтын газар хариуцах бөгөөд шаардлагатай тохиолдолд амраах, нөхөн сэргээх, эмчлүүлэх боломжоор хангана.

10.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч ажилдаа ирэх, ажлаас харих замд явсныг албан үүргээ гүйцэтгэж байгаатай адилтган тооцно.

11.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн төрийн тусгай хамгаалалтад байхаар тогтоосон барилга, бусад зүйлийн гадна цэгт болон далд хамгаалалтад ажилласан 1 жилийг 1 жил 4 сартай дүйцүүлэн тооцно.

12.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн харилцааг цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль тогтоомжид зааснаар зохицуулна.

13.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч хуульд заасан бусад баталгаагаар хангагдана.”

**4/18 дугаар зүйл:****“18 дугаар зүйл. Тагнуулын байгууллагын үүрэг**

1. Тагнуулын байгууллага хамгаалуулагчийн аюулгүй байдал болон хамгаалалтад сөргөөр нөлөөлж болзошгүй мэдээ, мэдээллээр төрийн тусгай хамгаалалтын газрыг хангаж, шаардлагатай бусад дэмжлэг, туслалцааг үзүүлнэ.

2. Тагнуулын байгууллага, төрийн тусгай хамгаалалтын газрын харилцан ажиллах, мэдээлэл солилцох журмыг Тагнуулын ерөнхий газрын дарга Төрийн тусгай хамгаалалтын газрын даргатай хамтран батална.

3. Тагнуулын байгууллагын орон нутаг дахь салбар, нэгж тухайн орон нутагт хэрэгжүүлэх төрийн тусгай хамгаалалтад хамтран оролцох цагдаагийн болон бусад байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж төрийн тусгай хамгаалалтын газарт дэмжлэг үзүүлнэ.”

3 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн Гуравдугаар бүлгийн гарчгийн “газар” гэснийг “байгууллага” гэж, 22 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “Тагнуулын төв байгууллагын дарга,” гэснийг “Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга,” гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4, 13.1.6 дахь заалт, 57 дугаар зүйлийн 57.4 дэх хэсэг, 57.5.4 дэх заалтын “тагнуул,” гэсний дараа “төрийн тусгай хамгаалалт,” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “тагнуул, сөрөг тагнуул, терроризмаас урьдчилан сэргийлэх асуудал;” гэсний дараа “-төрийн тусгай хамгаалалтын асуудал;” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9 дэх заалтын “нэгэн бүрэн эрхийн буюу 4 жилийн” гэснийг “2 жилийн” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 1 дүгээр зүйл, 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “тагнуул,” гэсний дараа “төрийн тусгай хамгаалалт,” гэж, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын “тагнуулын” гэсний дараа “болон төрийн тусгай хамгаалалтын” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 2 дугаар зүйлд “Төрийн тусгай хамгаалалтын байгууллагаас хуулиар төрийн тусгай хамгаалалтад байхаар тогтоосон Улсын Их Хурлын чуулган, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан, олон улсын дээд хэмжээний уулзалт, хэлэлцээ, хурал, зөвлөгөөн явагдах танхимд болон хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийх техникийн үзлэг, шалгалт гүйцэтгэх ажилд хамаарахгүй.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

ГАЛТ ЗЭВСГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Галт зэвсгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “Тагнуулын ерөнхий газрын” гэсний дараа “дарга, Төрийн тусгай хамгаалалтын газрын” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2.Эрдэнэсийн сангийн харуул хамгаалалтыг Төрийн тусгай хамгаалалтын газар эрхлэн гүйцэтгэнэ.”

2 дугаар зүйл.Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “бүрэн эрхийнхээ хугацаа дууссанаас эхлэн нэгэн бүрэн эрхийн буюу 4 жилийн” гэснийг “3 жилийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсгийн “нэгэн бүрэн эрхийн хугацаанд буюу дөрвөн жилийн” гэснийг “2 жилийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5.л дэд заалтын “хэрэгслийн” гэсний дараа “болон төрийн тусгай хамгаалалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, төсвийн” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5 дахь заалтын “шүүхийн шийдвэр биелүүлэх” гэсний дараа “, төрийн тусгай хамгаалалтын” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХ БОЛОН ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.1.9 дэх заалт нэмсүгэй:

“16.1.9.төрийн тусгай хамгаалалтын байгууллага.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “тагнуулын” гэсний дараа “болон төрийн тусгай хамгаалалтын” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтын албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн хэмжээ, сүлжээ, төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн болон төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээг тогтоохдоо эрх зүйн байдал, нийгмийн баталгааг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байх зарчмыг баримтална.

3 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газар Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг 2020 оны 06 дугаар сард багтаан зохион байгуулна.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.24, 3.1.25 дахь заалт:

“3.1.24. “эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ” гэж хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан төрөөс өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон үндсэн мэргэшлийн зарим нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг иргэн, гэр бүл, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор харьяалах нутаг дэвсгэрт байгаа хүн бүрд нь нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүйгээр үзүүлэх үйл ажиллагааг;

3.1.25. “эмнэлгийн урт хугацааны тусламж, үйлчилгээ” гэж сувилахуйн болон сэргээн засахын дагнасан тусламж, үйлчилгээг 1 сар ба түүнээс дээш хугацаагаар үзүүлэх үйл ажиллагааг.”

2/8 дугаар зүйлийн 8.1.24 дэх заалт:

“8.1.24. хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;”

3/8 дугаар зүйлийн 8.4-8.9 дэх хэсэг:

“8.4. Эрүүл мэндийн цахим бүртгэл, мэдээллийн сангийн өгөгдөл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглах журмыг Засгийн газар батална.

8.5. Энэ хуулийн 8.1.24, 19.3.3-т заасан үйл ажиллагааг зохион байгуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.6. Эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багцыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.7. Эмнэлгийн урт хугацааны тусламж, үйлчилгээг боловсрол, нийгмийн халамжийн үйлчилгээтэй хослуулан үзүүлэх журам, жагсаалтыг эрүүл мэндийн, боловсролын болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.



8.8.Энэ хуулийн 16.16-д заасан төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг улсын болон бүсийн хэмжээнд бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангах үйл ажиллагааг зохицуулах журам, тусламж, үйлчилгээний чиглэл, хамрах хүрээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.9.Хүний амь насанд аюултай, хөгжлийн бэрхшээлд хүргэдэг ховор тохиолдох өвчин, эмгэгийг тодорхойлох аргачлалыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

4/16 дугаар зүйлийн 16.19, 16.20 дахь хэсэг:

“16.19.Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг монголын уламжлалт анагаах ухааны үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

16.20.Энэ хуулийн 16.10-т заасан чиг үүрэгт хамаарах тусламж, үйлчилгээг нэг цэгээс хэд хэдэн хуулийн этгээд хамтран үзүүлж болно.”

5/44 дүгээр зүйлийн 44.1.6, 44.1.7 дахь заалт:

“44.1.6.өөрийн байгууллагын ажилтныг энэ хуулийн 8.5-д заасан журмын дагуу өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд товлосон хугацаанд хамруулах;

44.1.7.иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь үйлчлүүлэгч, түүний гэр бүл, асран хамгаалагчийн болон эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр өвчний онош, дүгнэлт, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ, үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн талаар мэдээлэл өгөхийг эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтнээс шаардах, олон нийтэд мэдээлэхийг хориглоно.”

2 дугаар зүйл.Эрүүл мэндийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг:

“16.4.Сум, тосгоны эрүүл мэндийн төв хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх орон нутгийн өмчит хуулийн этгээд байх бөгөөд байршил, хүн амын төвлөрөл, өвчлөл, осол гэмтлийн нөхцөл байдлаас хамааран яаралтай тусламж, үйлчилгээний болон багийн эмчийн салбартай байна.”

2/16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсэг:

“16.7.Клиник нь үндсэн, эсхүл төрөлжсөн мэргэшлээр эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээг амбулаторийн болон өдрийн эмчилгээ

хэлбэрээр, эсхүл амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх байгууллага байна.”

3/16 дугаар зүйлийн 16.10 дахь хэсэг:

“16.10.Нэгдсэн эмнэлэг 10 мянгаас доошгүй суурин хүн ам бүхий суманд эрүүл мэндийн анхан шатны болон таваас доошгүй үндсэн мэргэшлээр лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг, аймгийн төв, дүүрэгт долоогоос доошгүй үндсэн мэргэшлээр лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх байгууллага байна. Аймгийн төв, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа нэгдсэн эмнэлэг хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан зарим төрөлжсөн мэргэшлээр лавлагаа шатлалын нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг нэмэлтээр үзүүлж болно.”

4/16 дугаар зүйлийн 16.16 дахь хэсэг:

“16.16.Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг улсын болон бүсийн хэмжээнд төрөлжсөн мэргэшлээр эмнэлгийн лавлагаа шатлалын мэргэшсэн тусламж, үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх, сургалт судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхлэх, бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүйгээр ханган ажиллах чиг үүрэг бүхий байгууллага байна.”

5/17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэг:

“17.4.Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, энэ хуулийн 16.10-т заасан суман дахь нэгдсэн эмнэлгээс бусад нэгдсэн эмнэлгийн удирдлагыг эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл, түүнээс томилсон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.”

6/33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэг:

“33.2.Энэ хуулийн 33.1-д заасан шинжилгээ болон амьд сорьцын эмгэг эд, эс судлалын шинжилгээ хийх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

3 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.24 дэх заалтын дугаарыг “8.1.25” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.9 дэх хэсгийн “29.2,” гэснийг хассугай.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 05 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 45

Улаанбаатар
хот

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг баталсантай холбогдуулан уг хуулийг дагаж мөрдөх бэлтгэлийг хангах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай:

1/Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, 2020 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг энэ

хуульд нийцүүлэн боловсруулж, Улсын Их Хуралд 2022 оны 6 дугаар сард багтаан өргөн мэдүүлэх;

3/Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг энэ хуульд нийцүүлэх ажлыг зохион байгуулж Улсын Их Хуралд танилцуулах;

4/Төсвийн тухай болон холбогдох бусад хуулийг энэ хуульд нийцүүлэн боловсруулж, Улсын Их Хуралд 2020 оны 10 дугаар сарын 01-ний дотор өргөн мэдүүлэх;

5/Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан холбогдох журмыг 2020 онд багтаан боловсруулж, батлах;

6/Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг улсын хэмжээнд төрийн байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /С.Бямбацогт/, Төсвийн байнгын хороо /Б.Чойжилсүрэн/, Эдийн засгийн байнгын хороо /Ж.Ганбаатар/-нд тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 05 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 56

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-



ийн Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын тохируулагч агентлаг” гэсэн хэсэгт “4.Төрийн тусгай хамгаалалтын газар” гэж нэмсүгэй.

2.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн “Засгийн газрын тохируулагч агентлаг” гэсэн хэсгийн “4, 5, 6, 7, 8, 9, 10” гэсэн дугаарыг “5, 6, 7, 8, 9, 10, 11” гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 3.25

Индекс: 200003